



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/161

Улаанбаатар хот

Б.Мөнхбаярт буцалтгүй тусламж олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захиргаа, санхүүгийн хэлтсийн Иргэдийн өргөдөл, эрэлт хүсэлт үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Баяртунгалагийн Мөнхбаярын өвөг эцэг нас барсан тул дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.8.1-д заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буцалтгүй тусламж олгосугай.

2. Б.Мөнхбаярт буцалтгүй тусламж болох 320.000 /гурван зуун хорин мянга/ төгрөгийг тэтгэмж урамшуулалын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Ч.ГАНТӨМӨР

